



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/2023

Ксөнбулаг

Г  
Шинэ жилийн баярын өдрүүдэд  
болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх  
арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шинэ жилийн баяр, амралтын үеэр цахилгаан, дулаан, усан хангамж, сумдын болон онцгой объектуудын хэвийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах аймгийн хариуцлагатай жижуурний хуваарийг нэгдүгээр хавсралтаар, жижуурний ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аймаг, сумдын удирдлага, ард иргэдэд цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх сэргээллүүлэг, мэдээллийг толтмол хүргэж, болзошгүй гамшигийн үед гамшигаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сумдын удирдлагыг мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг Онцгой байдлын газар (дэд хурандаа Ц.Лувсанжамц)-т даалгасугай.

3. Шинэ жилийн баяр, амралтын өдрүүдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам сахиулах нэгдсэн болон тусгай арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Цагдаагийн газар (хурандаа Н.Мэндбаяр)-т үүрэг болгосугай.

4. Аж ахуйн нэлж, байгууллагын хэмжээнд аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагааг хангахад хяналт тавих эргүүл, жижуурний томилон ажиллуулж, Онцгой байдлын газрын 77480101 дугаарын утсанд цаг үеийн холбогдолтой мэдээ, мэдээллийг өдөр бүрийн 10.00, 20.00 цагуудад, яаралтай мэдээ, мэдээллийг тухай бүр нь өгч ажиллахыг гамшигаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сумдын удирдлага, байгууллага, аж ахуйн нэгжийн дарга наарт үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг нэгтгэн 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 12.00 цагийн дотор танилцуулахыг Онцгой байдлын газар (дэд хурандаа Ц.Лувсанжамц)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг дартын 2023 оны  
12 дугаар сарын ~~17~~-ны өдрийн ~~1003~~ дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт

АЙМГИЙН ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮРИЙН  
АЖИЛЛАХ ЖУРАМ

1. Аймгийн хариуцлагатай жижүүр нь Онцгой байдлын газар дээр төвлөрч 24 цагаар үүрэг гүйцэтгэнэ.

2. Хариуцлагатай жижүүрүүд үүрэг гүйцэтгэсэн хугацаандаа дэлгэрэнгүй тэмдэглэл хөтөлж дараагийн жижүүрт дараагийн өдрийн 09.00 цагт жижүүрийн үүргээ албан ёсоор хүлээлгэн өгнө.

3. Улсын онц чухал объектод өдөрт 2-оос доошгүй удаа хяналт тавьж, үйлчилгээний байгууллагууд, бусад шаардлагатай аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж тухайн байгууллагын дарга нартай байнгын холбоотой ажиллана. Шаардлагатай бол шуурхай зөвлөгөөн хийж болно.

4. Үүрэг гүйцэтгэх хугацаанд гэмт хэргийн шинж чанартай асуудал илэрвэл цагдаагийн байгууллагад шуурхай мэдэгдэж зохих арга хэмжээ авна.

5. Улсын онцгой комиссын Шуурхай штабт цагийн байдлаар мэдээлэл өгч ажиллана.

6. Аймгийн Засаг дарга, орлогч, Онцгой байдлын газрын даргад тогтмол мэдээлэл өгч, үүрэг чиглэл авч ажиллана.

7. Аймгийн төвийн байгууллага, аж ахуйн нэгжийн хариуцлагатай эргүүл жижүүрийг ерөнхий удирдлагаар хангаж, үүрэг чиглэл өгч, хэрхэн ажиллаж байгаад хяналт тавина.

8. Ажлын шаардлагаар холбогдох байгууллагын даргад мэдэгдэн мэргэжлийн хүн, хүчийг дайчлан ажиллуулж болно.

9. Ажиллах хугацааны унаа, шатахууны зардлыг тухайн байгууллага өөрөө хариуцна.

10. Иргэдээс гаргасан санал, хүсэлт, гомдлыг Онцгой байдлын газрын 7048105 дугаарын утсаар тухай бүр нь мэдэгдэнэ, ирсэн мэдээлэл, дуудлагын мөрөөр шаардлагатай арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллана.

11. Байгууллага, аж ахуйн нэгжүүд хариуцлагатай жижүүрийн шаардсан мэдээг цаг хугацаанд нь гаргаж өгөх үүрэгтэй.

—oo—